



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/26

Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх Сургуулийн өмнөх боловсролын багш нар, нийгмийн ажилтан, сургалтын менежер, дотуур байрны багш, арга зүйч, насан туршийн боловсролын багш нарыг компьютержуулах арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Үнэлгээний хорооны дарга: П.Хулан (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- О.Золжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
- М.Эрдэнэбилэг (Хөндлөнгийн төлөөлөл (тохиролцсон)
- С.Саруулсайхан (Есөнбулаг сумын иргэн)
- Нарийн бичгийн дарга: О.Даваажаргал (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (П.Хулан)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ